

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/010/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Сугармаа

Утас: 70272248 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ц.ГАНТӨМӨР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, 4 орон нутгийн тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 11 тайлан нэгтгэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь зөвхөн гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих 6 байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Баян сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03/02 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,108,735.6 мянган төгрөгөөр баталснаас 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 07/03 дугаар тогтоолоор 811,565.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,920,300.6 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 3,467,448.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 547,147.6 мянган төгрөгөөр буюу 18,7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 15 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ төлөвлөж ажилласан ба 78 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. 2025 оны сумын хөгжлийн төлөвлөгөө 20 зорилтын 97 арга хэмжээ төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 76,4 хувьтай хэрэгжсэн дүнтэй байна.

• 4126020653

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,985,841.54	6,748,019.41
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,504,455.09	6,179,391.93
3	1.1.3 АВЛАГА	2,400,200.08	444,918.05
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	81,186.37	123,709.44
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,355,111.1	12,845,968
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,355,111.1	12,845,968
7	1.2.2.02 Биет хөрөнгө	3,648,050.6	3,761,137.5
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	707,060.5	9,084,830.5
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	10,340,952.64	19,593,987.41
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	207,357.74	507,186.32
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	207,357.74	507,186.32
12	2.1.1.03 Өглөг	207,357.74	507,186.32
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,133,594.9	19,086,801.09
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	10,133,594.9	19,086,801.09
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	1,268,467.93	1,268,467.93
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	7,904,404.79	16,857,610.99
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	960,722.18	960,722.18
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	10,340,952.64	19,593,987.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	8,709,630.19	13,848,241.84
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,534,778.65	2,862,771.82
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	1,072,767.18	2,425,056.05
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	1,072,767.18	2,425,056.05
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	73,353.26	74,432.28
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	388,658.21	363,283.48
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,880,819.22	10,985,470.02
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого	68,860.38	225,286.59
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,294,032.32	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,598,102.62	2,510,568.41
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,668,353.19	2,506,768.41
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,634,283.04	2,099,395.19
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,212.71	812,447.06
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,777.12	94,026.73

**Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,664.04	552,507.08
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	46,173.7	43,829.14
17	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	16,165.55	46,125.04
18	1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	6,566	8,170
19	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,387.86	21,000.22
20	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	441,336.05	521,289.93
21	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,070.15	407,373.23
22	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,929,749.43	3,800
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,111,527.57	11,337,673.42
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	348,996.15	506,141.3
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-348,996.15	-506,141.3
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	4,762,531.42	10,831,532.12

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,870,075.56	5,193,995.89
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,534,778.65	2,862,771.82
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	1,072,767.18	2,425,056.05
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	73,353.26	74,432.28
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	388,658.21	363,283.48
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	31,375.55	39,979.6
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	292,454.66	260,663.89
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	64,828	62,640
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,024,365.29	2,331,224.08
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	2,955,504.92	722,481.6
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	68,860.38	117,795.17
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,490,947.3
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,310,931.62	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,362,185.44	2,075,033.09
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,362,185.44	2,075,033.09
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,328,235.28	1,667,419.87
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,212.71	812,447.06
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,777.12	94,026.73
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	429,242.94	552,507.08
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	43,664.26	33,745.35
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	1,145.9

**Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	22,090.49	49,790.1
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	6,566	8,024
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,888.81	68,024.31
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	78,792.96	47,709.35
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,950.15	407,613.23
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,507,890.13	3,118,962.8
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,241,223.43	334,632.66
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,241,223.43	334,632.66
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	3,241,223.43	334,632.66
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,241,223.43	-334,632.66
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	90,667.4	109,393.3
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-90,667.4	-109,393.3
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,175,999.3	2,674,936.84
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,328,455.79	3,504,455.09
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,504,455.09	6,179,391.93

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,371,063.48	5,371,063.48
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	869.27	869.27
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,371,932.76	5,371,932.76
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-869.27	-869.27
5	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	4,762,531.42	4,762,531.42
6	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,133,594.9	10,133,594.9
7	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,133,594.9	10,133,594.9
8	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,878,325.93	-1,878,325.93
9	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,255,268.97	8,255,268.97
10	1.7 Тайлант үеийн үр дүн	10,831,532.12	10,831,532.12
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	19,086,801.09	19,086,801.09

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
------------	-------------------	---------------	--------------	-------	------

**Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,475,242.5	5,129,790.24	334,109.29	114.6
11	3.1.01.1.1 Татварын орлого	2,840,300.60	2,862,771.82	(22,471.22)	100.79
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	1,800,444.10	2,425,056.05	(624,611.95)	134.69
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	139,556.50	74,432.28	65,124.22	53.33
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	900,300.00	363,283.48	537,016.52	40.35
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,500.00	39,979.60	(24,479.60)	257.93
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	676,000.00	260,663.89	415,336.11	38.56
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	208,800.00	62,640.00	146,160.00	30.00
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,634,941.9	2,267,018.42	356,580.51	92.17
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	134,826.90	776,071.12	(641,244.22)	575.61
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,500,115.00	1,490,947.30	9,167.70	99.39
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,666,291.50	1,998,861.77	5,667,429.73	26.07
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,139,939.90	1,560,045.81	579,894.09	72.90
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,726,317.60	1,492,637.79	233,679.81	86.46
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,636.40	723,982.03	31,654.37	95.81
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,219.10	83,606.08	11,613.02	87.80
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	570,441.30	552,507.08	17,934.22	96.86
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	47,360.70	32,457.65	14,903.05	68.53
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,190.00	1,145.90	44.10	96.29
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	84,030.00	43,990.50	40,039.50	52.35
2107	3.1.01.2.1.1.7 Томилт, зочны зардал	11,700.00	8,024.00	3,676.00	68.58
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,545.10	15,504.70	13,040.40	54.32
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	132,195.00	31,419.85	100,775.15	23.77
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	413,622.30	67,408.03	346,214.27	16.30
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	73,417.10	67,408.03	6,009.07	91.82
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,416,958.30	329,422.66	5,087,535.64	6.08
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	109,393.30	109,393.30	-	100
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,423,265.05		
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,106,496.89		

**Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	60.00	52.00	8.00	86.67
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100
62	6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	25.00	4.00	86.21
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	25.00	4.00	86.21

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	830,075.3	225,286.6
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	830,075.3	225,286.6
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	830,075.3	225,286.6
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	830,075.3	225,286.6
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	830,075.3	225,286.6
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,000.0	-
350013	1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,587.6	99,382.3
350014	1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	514,741.4	10,798.6
350015	1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	205,746.3	115,105.7
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	830,075.3	131,672.5
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	259,132.2	131,672.5
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,935.8	131,672.5
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,406.9	88,465.0
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,012.6	10,420.6
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	6,071.2	1,287.7
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,799.6
2107	1.1.1.2.1.1.7 Томилот, зочны зардал	630.0	0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	891.5	4,200.0
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	43,923.6	21,499.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	570,943.2	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,196.4	0
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	107,548.8	93,614.1

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй ба 755,045.7 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 639,604.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага 115,440.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт алдаа, зөрчлөөс 755,045.7 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус бөгөөд материаллаг алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй болно.

5.2. Албан шаардлага

1.Өмнөх оны аудитаар “Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч 6 нэр төрлөөр буюу 435,493.8 мянган төгрөгөөр тасарсан” зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд 7 нэр төрлийн 639,604.9 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5.-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлан болон татварын мэдээнд 5 нэр төрлийн орлого 503,412.5 мянган төгрөгөөр дутуу, 8 нэр төрлийн орлого 624,640.4 мянган төгрөгөөр илүү нийт дүнгээр 115,440.8 мянган төгрөгөөр дутуу буюу зөрүүтэй мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 24 дүгээр зүйлийн 24.3-д “Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын мэдээг үнэн зөв мэдээлж буй эсэхэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг дарга	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
3	Засаг даргын тамгын газар	1	1			1			
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
7	Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа сан	1		1					
8	Соёлын төв	1		1					
НИЙТ		8	2	6		2			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	3	8,812,255.8			3	8,812,255.8	3	8,812,255.8		
Эмийн эргэлтийн сан	2	21,026.8			2	21,026.8	2	21,026.8		
Дүн	5	8,824,323.2			5	8,824,323.2	5	8,824,323.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Нийт зөрчил	Үүнээс
-------------	--------

**Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Байгууллагын нэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	755,045.7			1	639,604.9	1	115,440.8		
ЗДТГ	7	407,465.2			3	17,654.0	4	389,811.2		
ИТХ	4	4,873.9	2	3,500.0			2	1,373.9		
Хоршоо хөгжүүлэх сан	1	108,000.0					1	108,000.0		
Эмийн эргэлтийн сан	2	24,335.7					2	24,335.7		
Дүн	16	1,299,720.4	2	3,500.0	3	657,258.9	9	638,961.6		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn